



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар A/72

Улаанбаатар хот

Стандартчиллын техникийн болон дэд
хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 25 дугаар зүйлийн 25.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стандартчиллын техникийн болон дэд хороодын бүрэлдэхүүнийг 1-ээс 64 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/158, 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/108, 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/06, 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/77, 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/78, 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/90, 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/147, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/129, 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/130, 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/41, 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/62, 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар баталсан Стандартчиллын техникийн болон дэд хороодын бүрэлдэхүүнийг хүчингүйд тооцсугай.

3. Техникийн хорооны Дарга, гишүүдээс “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг тухай бүр гаргуулан, Стандартчиллын техникийн болон дэд хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж ажиллахыг Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газар (Д.Даваасүрэн)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.УУГАНБАЯР

XTHU3154 9020030641 9096035

130000730

Стандарт, хэмжил зүйн газрын дарын
2023 оны 04 дүгээр сарын 05-ний өдрийн
А/74 дугаар тушаалын 60 дугаар хавсралт

ХТУЗ154 9020030641 9036035

Авто замын стандартчиллын техникийн
хорооны бүрэлдэхүүн (TX48)

Дарга:	Д.Гэрэлням	Зам, тээврийн хөгжлийн яамны бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Жинхэнэ гишүүд (Р):	Ш.Гэрэлт-Од	Зам, тээврийн хөгжлийн яамны салбарын хяналтын газрын авто зам хариуцсан ахлах шинжээч
	Ч.Намшир А.Хурцбилэг	"Ти Ай Би" компанийн ерөнхий инженер Замын хөдөлгөөн судлалын хүрээлэнгийн захирал
	И.Базаррагчаа	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Механик тээврийн сургуулийн Тээврийн хэрэгслийн профессорын багийн ахлах багш Зам тээврийн хөгжлийн төвийн Зүүн бүс хариуцсан хяналтын инженер
	М.Ган-Эрдэнэ	"Лабо" ХХК-ийн зөвлөх инженер, Монгол улсын зөвлөх инженер
	Ч.Лхагважав	Нийгмийн автозамын газрын төлөвлөлт судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
	О.Энхбаатар	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Барилга архитектурын сургуулийн ахлах багш, доктор (Ph.D)
	Р.Болормаа	"Ундрах говь" ХХК-ийн захирал, Монгол улсын зөвлөх инженер
	Н.Батсуурь	"Чингис лэнд девелопмент" группийн ерөнхий инженер, Зөвлөх инженер
	Ж.Даваасүрэн	Монголын авто инженерүүдийн холбоо ТББ-ын гишүүн
	Ж.Мягмаржав	
	Ж.Сэрээтэр	Монгол Улсын зөвлөх инженер
	Р.Нарантуяа	Авто замын материалын инженер, судлаач, докторант
	О.Наранбаатар	Монголын авто замчдын инженерийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал
	Н.Сэмжид	"Кад сүрвэй" ХХК-ийн инженер
	М.Угтахбаяр	"Интегрити инженеринг" ХХК-ийн захирал
	Д.Базарсад	"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын стандартын хэлтсийн дарга